



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 5/240

Арвайхээр

Г Захирамжийн зарим хэсэгт өөрчлөлт оруулж, Т өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 166 дугаар тогтоол, 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 127 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 22 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 127 дугаар тогтоолоор гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгасантай холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 2020 оны 06 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасугай.

2. Аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/204 дүгээр захирамжийн 2 дахь заалтын согтууруулах ундаа худалдах заалтыг хэвээр үлдээж, аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдах цагийг 2020 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс 06 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд 08:00-20:00 байхаар хязгаарлалт тогтоож, баар, караоке, цэнгээний газруудын үйл ажиллагааг дээрх хугацаагаар түр зогсоосугай.

3. Сургалтын төвүүдийн танхимины сургалтын үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас гаргасан зөвлөмж, шаардлагыг хангаж ажиллуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа О.Ганбат), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011100521